

2025 оны 08 сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот



### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

#### Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

##### Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32 дахь заалтад “Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2026 төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

##### Практик шаардлага

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримталдаг итгэлцүүрийг жил бүр шинэчлэхээр заасан. Итгэлцүүрийг жил бүр улсын дундаж цалин хөлс, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлснээр өөрийн төлсөн шимтгэлийн өнөөгийн үнэ цэнд нийцэхүйц өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах боломж бүрдэх юм.

Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж өндөр насны тэтгэврийг 2023 оны 7 дугаар сараас 10 хувь, 2024 оны 4 дүгээр сараас 100.0 мянган төгрөгөөр, 2025 онд 6 хувиар тус тус нэмэгдүүлээд байна. Нийгмийн даатгалын

сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэврийг жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр байна.

Хүн амын өсөлт, дундаж цалингийн өөрчлөлтөөр тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ жил бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор хүн, амын статистик тоон үзүүлэлтээр сангийн орлого, зарлагыг нэмэгдүүлж тооцох шаардлагатай.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 бүлэг, 7 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрх хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2026 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид

бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---